

ГИПЕРТЕКСТ НЬ НЭН ШИНЭ ҮЕИЙН ХҮҮРНЭЛ ЗОХИОЛЫН ДҮРСЛЭЛИЙН НЭГЭН ХЭВ МАЯГ БОЛОХ НЬ

П.Яньдий (МУБИС, НХУС, Утга зохиолын тэнхим)

Гипертекст бол тооцоололтой холбоотой ойлголт юм. Энэ нь текстийн хэсгүүдийг хооронд нь холбох боломжийг олгодог системийг хэлдэг бөгөөд энэ нь хэрэглэгчийг дараалсан байдлаар бус харин холбогдох зүйлээр дамжуулан мэдээлэл авах боломжийг олгодог байна. Гипертекстийн тухай ойлголтыг 1960-аад онд Америкийн философич, социологич Теодор Холм Нельсон тооцоолол, интернэт бий болсноор үүссэн шугаман бус, интерактив шинэ уншилтыг тодорхойлох зорилгоор бүтээжээ. Гипертекстийн алдартай жишээ бол интернетийн нийтлэлүүд бөгөөд текстийн үндсэн хэсэгт үндсэн сэдэв эсвэл хөгжүүлэлтэд хамаарах үгс эсвэл сэдвээр янз бүрийн линк, гипертекст холбоосыг оруулдаг бөгөөд энэ нь уншигчдад илүү идэвхтэй унших боломжийг олгодог байна.

Дэлхийн улс орнуудын урлаг, уран зохиолын туурвилзүйд гипертекст буюу эх текст, эш бичвэр гэх ойлголт бий. Энэ тухай профессор С.Энхбаяр *“Аль ч улс үндэстэнд тухайн ард түмэн болоод бүс нутгийн соёлын язгуур эх сурвалж, шавхдашгүй ундарга, оюун санааны суурь үндэс, ариун өлгий болсон текстүүд байдаг. Постмодернизмд үүнийг гипертекст гэдэг томьёоллын дор авч үздэг.”* /С.Энхбаяр (2011). Утга зохиолын онол. Улаанбаатар.274-р тал/ гээд барууны соёл иргэншил, оюун санааны эх сурвалж нь Библи бөгөөд өрнө дорны сонгодог урлаг утга зохиолыг Библийн үзэл санаагүйгээр төсөөлж ойлгож үл болно гэх мэтээр тайлбарласан бол доктор Г.Батсуурь *“Сагалгар мод”* хэмээх шүүмжийн өгүүлэлдээ *“Монгол үндэстний соёлын онцгой шилжилтийн үе, алив үндэстний олон соёлын мөргөлдөөн, даяарчлалын эрн үед бусад үндэстнээс ялгаран үлдэх мөн чанар нь гагцхүү бидний гипертекстүүдэд буюу “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар”, эртний баатарлаг туульс, домог зүйн тогтолцоо энэ мэт уран бүтээлүүд хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлаас үзэж болно.”* (Г.Батсуурь (2017).Сагалгар мод. /Уран зохиолын тухай яриа/ Улаанбаатар. 182-р тал) хэмээн дүгнэсэнтэй бид санал нэг төдийгүй эдгээр эрдэмтэн судлаачдын тайлалзүйд дулдуйдан нэн шинэ үеийн хүүрнэл зохиолын дүрслэлийн нэг хэв маягийг гипертекст мөн болохыг дараах зохиолчдын уран бүтээлээр нотлохыг зорьсон болно.

Хэдийгээр шинэ зуун гараад хориод жилийг ардаа үдсэн ч энэ хугацаа богинохон мэт боловч хүн төрлөхтний хувьд хамгийн хурдацтай он жилийг туулж буйг цахим ертөнц бэлхэнээ харуулж байна. Сүүлийн жилүүдэд Г.Аюурзаны *“Амь тавьж буй шувууны далавч”/2006/*, *“Шүгдэн”/2012/*, *“Цагаан хар улаан”/2014/* болон Б.Батрэгээдмаагийн *“Очир эрхшээгч”/2014/*, Г.Мэнд-Ооёогийн *“Гэгээнтэн”(2012)*, Н.Нагаанбуугийн *“Алтан тэнгэр”/2014/*, Ц.Буянзаяа *“Морин уруул”/2016/*, *“Зүүдэн дотрох зүүд”/2008/*, Ц.Цэнд *“Дөрвөн нүдтэй зүүд”/2002/* ... гэх мэт олон бүтээл гарчээ. Эдгээр бүтээлүүдийн өгүүлэмж нь бүхэлдээ домог зүй болоод монголын уран зохиолын гурван оргилын нэг *“Монголын нууц товчоо”*, буддын олон судруудаас шигтгэн оруулж зохиолынхоо үйл явдлыг сонирхолтой, зөрчилтэй, ээдрээтэй болгож уншигчдын сонирхолыг татахуйцаар урлан бүтээсэн нь гипертекстийг урлалзүйн гол арга болгосны илрэл юм.